

2026 оны дугаар сарын -ны өдөр

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсад анх 2012 онд шүүхийн шинэчлэлийн багц хуулийн хүрээнд шүүхийн ачааллыг бууруулах, эрх зүйн маргааныг шийдвэрлэх сонголтот хувилбарыг хөгжүүлэх зорилгоор Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг¹ баталсан.

Уг хууль хэрэгжиж эхэлснээс хойш тус нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт орж, шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч эрх зүйч мэргэжилтэй байх, шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш талууд эвлэрсэн бол улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тал хувиар бууруулж тогтоох зэрэг шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд чиглэсэн зохицуулалтыг нэмж тусгасан байна.²

Тус хууль батлагдсанаар маргааныг эвийн журмаар, шуурхай, зардал багатай шийдвэрлэх чиглэлээр тодорхой ахиц гарсан хэдий ч институцийн бүтэц болон практик хэрэглээг сайжруулах, тэр дундаа эдийн засаг, бизнесийн салбарын хөгжилд нийцүүлэн арилжааны маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх хэрэгцээ шаардлага нэгэнт бий болжээ.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн³ 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасны дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ⁴ болон хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайланд⁵ үндэслэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагыг тодорхойлж байна.

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.2-т “Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлнэ.” гэж, 3.2.2.6-д “Арилжаа, бизнес эрхлэгчдийн хоорондын маргааныг шүүхийн бус журмаар шуурхай шийдвэрлэх эрх зүйн тогтолцоог сайжруулна.” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 39-д эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн

¹ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2012), №25

² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8689>

³ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2015), №25

⁴ “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь” судалгааны тайлан. ХЗҮХ (2023)

⁵ Эвлэрүүлэн зуучлалын тухай шинэчилсэн найруулгын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан. Судлаач Г.Цагаанбаяр, О.Буян-Ундрах (2024)

зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зорилгоор Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

1.2. Практик шаардлага

1/Шүүхээс гадуурх эвлэрүүлэн зуучлалын бодит хэрэгжилт хангалтгүй түвшинд байгаа, түүнчлэн эвлэрлийн гэрээг баталгаажуулах асуудлыг хуулиар зохицуулаагүй тул төрийн бус, эсхүл мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчдад хандах итгэл бага, эвлэрлийн гэрээ байгуулсан ч гэрээний үүргээ гүйцэтгээгүй бол дахин шүүхэд хандаж маргаанаа шийдвэрлүүлэх эрх зүйн зохицуулалттай байгаа зэрэг нь шүүхийн бус эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхгүй байх, хөгжихгүй байх шалтгаан нөхцөл болоод байна.

Монгол Улсад шүүх дэх эвлэрүүлэн зуучлал болон шүүхээс гадуур бусад байгууллага дахь эвлэрүүлэн зуучлал байх холимог тогтолцоог хуульчилсан бөгөөд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх, сайжруулахад чиглэгдсэн байна хэмээн дүгнэжээ.⁶

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны статистик тоон мэдээллээс үзвэл, 2014 оноос 2020 оныг хүртэлх 6 жилийн хугацаанд нийт 223,468 иргэний хэргээс 47,587 хэрэг буюу дунджаар нийт иргэний хэргийн 17.2 хувийг эвлэрүүлэн зуучлах ажиллагаагаар амжилттай шийдвэрлэсэн бөгөөд энэ нь иргэний хэргийн шүүхийн ачааллыг тэр хувиар багасгаж буй ач холбогдолтой юм.⁷

Хэдийгээр эвлэрүүлэн зуучлалын холимог хэлбэрийг сонгосон нь сайшаалтай, шүүхийн ачааллыг тодорхой хувиар бууруулж байгаа хэдий ч шүүхээс гадуурх төрийн болон төрийн бус мэргэжлийн холбооны дэргэдэх эвлэрүүлэн зуучлалд хандсан тоо бага, тодорхой тооны эвлэрлийн гэрээ байгуулсан боловч гэрээний биелэлт хангалтгүй байна.⁸

Тодруулбал, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Бизнесийн маргааныг эвлэрүүлэн зуучлах төв нь 2014 онд байгуулагдан 2015 оны 3 дугаар сар хүртэл нийт 85 хүсэлт хүлээн авснаас 32 хүсэлтэд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа явуулахаас татгалзаж (гэр бүл, хөдөлмөрийн маргаантай холбоотой), 22 хүсэлтэд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болж, 31 эвлэрлийн гэрээг байгуулсан. Эвлэрлийн гэрээг төрлөөр нарийвчилбал, худалдах, худалдах авах гэрээ 28 хувь, ажил гүйцэтгэх гэрээ 13 хувь, зээлийн гэрээ 9 хувь, барилгын ажил гүйцэтгэх гэрээ 19 хувь, тээвэр зуучлалын гэрээ 6 хувь, гэр бүлийн эрх зүйн маргаан 4 хувь, бусад маргаан 21 хувийг тус тус эзэлж байжээ. Гэхдээ 2015 оны 3 дугаар сараас хойш өргөдөл, хүсэлт хүлээн аваагүй үйл ажиллагаа нь зогсонги байдалтай байна.⁹

Мөн Улаанбаатар хотын Худалдааны Танхимын дэргэдэх Эвлэрүүлэн Зуучлах Төв нь 2015 онд байгуулагдсан боловч байгуулагдсан цагаас хойш үйл

⁶ “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ”, “Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг” ТББ, 2020 он, 84 дахь тал.

⁷ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тойм”, Шүүх эрх мэдэл сэтгүүл №2, 2020 он, 128 дахь тал.

⁸ Эвлэрүүлэн зуучлалын тухай шинэчилсэн найруулгын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан. Судлаач Г.Цагаанбаяр, О.Буян-Ундрах (2024)

⁹ мөн тэнд.

ажиллагаа нь төдийлөн амжилттай явагдаагүй бөгөөд төвийн үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон, нэг ч маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахгүй байна.¹⁰

Иймд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны дэргэдэх буюу хувийн хэвшлийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлалын хэрэглээг нэмэгдүүлэх, эвлэрлийн гэрээг баталгаажуулах, заавал биелэгдэх эрх зүйг орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

2/Олон улсын туршлагаас үзэхэд шүүх болон эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зохистой харьцааны хэмжээ нь шүүх дэх 2 маргаан тутмын нэг нь эвлэрүүлэн зуучлалаар орж, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дүнд 50-аас дээш хувийн амжилттай эвлэрэл явагдсан бол үр нөлөөтэй эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо хэрэгжиж байна¹¹ гэж үздэг бол Монгол Улсад шүүх дэх эвлэрүүлэн зуучлал амжилттай хэрэгжиж байгаа хэдий ч шүүгчдийн ажлын ачаалал хэт өндөр, шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын ажлын ачаалал мөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор хувийн буюу төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэдэх эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх, бэхжүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн.

Тодруулбал, нийгэм эдийн засгийн хөгжлийн нөлөөгөөр иргэний хэргийн шүүхийн маргаан их, нэг шүүгчид ногдох ажлын ачаалал хэт өндөр, нэг шүүгчид ногдож байгаа хэрэг, маргааны тоо жил бүр өсөж байгаагийн улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа төдий хэмжээгээр удаашрах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарт нөлөөлөх, улмаар шүүхэд итгэх иргэдийн итгэл буурах зэрэг сөрөг үр дагаврууд хэвээр байгаа нь эвлэрүүлэн зуучлалыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг үүсгэсэн.

Статистик мэдээллээс үзэхэд, дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2023 онд 81.6 шүүгч ажиллаж байсан бөгөөд нэг шүүгчид дунджаар 510.1 хэрэг ногдож байсан¹² бол 2024 онд 80 шүүгч ажиллаж, нэг шүүгчид дунджаар 654.2 хэрэг¹³, 2025 онд 69.2 шүүгч ажилласан бөгөөд нэг шүүгчид дунджаар 465.5 иргэний хэрэг ногдож байсан байна.¹⁴ Түүнчлэн, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх байгуулагдаж, 2025 оны байдлаар тус шүүх нийт 51,038 нэхэмжлэл, хэргийг хүлээн авч, 28,611 хэргийг шийдвэрлэсэн байна.¹⁵ Эдгээр тоо баримтаас үзэхэд иргэний хэргийн тоо цаашид өсөх хандлагатай бөгөөд үүнийг дагаад нэг шүүгчид ногдох хэргийн тоо нэмэгдэх төлөвтэй байна.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын ажлын ачаалал мөн ихэсч байгаа нь өргөдлийг буцаах, эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр нөлөө, чанар буурах үр дагавар үүсэх эрсдэлтэй байна.

Тухайлбал, Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч “Ачаалал ихтэй дүүргийн шүүх дэх эвлэрүүлэн зуучлал дээр

¹⁰“Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх нь” судалгааны тайлан. ХЗҮХ (2023)

¹¹The Implementation of the Mediation Directive.

https://www.europarl.europa.eu/RegData/etudes/IDAN/2016/571395/IPOL_IDA%282016%29571395_EN.pdf?fbclid=IwAR1C5HmDkCo00-ReQnusKIP8805OmCTD3Xgb56OBi1-86eg12T-2oJbKJA

¹² Монгол улсын шүүхийн 2023 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ.

¹³ Монгол улсын шүүхийн 2024 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ.

¹⁴ Монгол улсын шүүхийн 2025 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ.

¹⁵Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн “Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”-ны зохицуулалтад хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан. Судлаач Н.Норовсамбуу (2026)

гэр бүлийн маргааныг хүлээн авч шийдвэрлэдэг эвлэрүүлэн зуучлагч, эсхүл сэтгэл зүйчийн орон тоо нэмэгдүүлэх шаардлагатай байна. 2021 онд нэг эвлэрүүлэн зуучлагчид ногдох өргөдлийн тоо 1324 байгаа нь ажлын ачаалал ихсэж,¹⁶ 1 өргөдлийг шийдвэрлэх хугацаа багассанаар өргөдөл шийдвэрлэлтийн чанар буурах магадлалтай байна” үзжээ.

Нөгөөтэйгүүр, шүүхийн статистик мэдээллээс харахад 2025 онд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан 20628 өргөдлөөс 14822 өргөдлийг шийдвэрлэж, тус шийдвэрлэсэн 14288 өргөдлөөс 8990 буюу 62.9 хувьд нь эвлэрэл амжилттай болж, 3305 буюу 23.1 хувьд нь эвлэрэл амжилтгүй болсон байна.¹⁷ Мөн 2025 оны бүтэн жилд нийт 72716 (хэрэгсэхгүй болгосон хэргийг хассанаар) иргэний хэрэг шийдвэрлэсэн бол шүүх дэх эвлэрүүлэн зуучлалаар 8990 өргөдлийг амжилттай шийдвэрлэсэн нь иргэний хэргийн 12.4 хувь байна.¹⁸

Иймд эвлэрүүлэн зуучлалын тусламжтайгаар шийдвэрлэх маргааны төрлийг өргөжүүлэх, эвлэрүүлэн зуучлагчийн эрх зүйн статусыг тодорхой болгох, чадавх, нийгмийн баталгааг сайжруулах хэрэгцээ, шаардлага бий болсон байна.

3/Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр талууд маргаанаа шийдвэрлүүлэх тохиолдолд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд¹⁹ заасны дагуу маргааны үнийн дүнгээс үл хамааран 30000 төгрөгийн хураамжтай байхаар тогтоосон. Энэ нь 1.300.000 төгрөгөөс доош үнийн дүнтэй маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхэд төлөх улсын тэмдэгтийн хураамжаас өндөр байх боловч, 1.300.000 дээш үнийн дүнтэй маргааны хувьд шүүхэд төлөх улсын тэмдэгтийн хураамжаас эвлэрүүлэн зуучлалын тэмдэгтийн хураамж бага байна гэсэн үг.

Үүнээс гадна шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд үнийн дүн өндөр, хэдэн тэрбумын шаардлага бүхий маргаанд эвлэрэх тохиолдол цөөнгүй, үүнд ч мөн адил улсын тэмдэгтийн хураамж 30000 төгрөг байгаа нь хэт бага гэх шүүмжлэл байна. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль 2012 оноос хойш хэрэгжээд даруй 14 жил болсон ч улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг эдийн засгийн нөхцөл байдал, инфляцтай уялдуулах байдлаар шинэчлэн тогтоогоогүй байна.

Иймд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын тэмдэгтийн хураамжийг интервалтай болгох, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тэмдэгтийн хураамжийг шинэчлэн тогтоох хэрэгцээ шаардлагатай байна.

4/Хуулийн хэрэгжилтийн явцад тус хуулийн хүрээг өргөжүүлэх, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын эвлэрлийн маргаан шийдвэрлэх ажиллагааны процессыг нарийвчлан тусгах, гэрээний биелэлтийг хангуулах, нэр томъёог жигдлэх, хийдлийг арилгах, олон улсын жишигт нийцүүлэх хэрэгцээ, шаардлага бий болжээ.²⁰

5/Мөн эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг олон улсын чиг хандлагад нийцүүлэх, арилжааны болон хил дамнасан эвлэрлийн гэрээ байгуулах механизмыг бүрдүүлэх, цахим хэлбэрээр эвлэрлийн гэрээ байгуулах боломжийг бий болгох

¹⁶ Эвлэрүүлэн зуучлалын тухай шинэчилсэн найруулгын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан. Судлаач Г.Цагаанбаяр, О.Буян-Ундрах (2024)

¹⁷ Монгол улсын шүүхийн 2025 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ. 63 дахь тал.

¹⁸ Мөн тэнд.

¹⁹ Төрийн мэдээдэл эмхэтгэл (2011), №01

²⁰ Эвлэрүүлэн зуучлалын тухай шинэчилсэн найруулгын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан. Судлаач Г.Цагаанбаяр, О.Буян-Ундрах (2024)

шаардлагын хүрээнд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг шинэчлэн найруулах нь зүйтэй байна.²¹

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- Шүүхийн бус журмаар эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зохицуулалтыг нарийвчлан тусгах бөгөөд эвлэрүүлэн зуучлах төрийн бус байгууллагын үйл ажиллагааны талаар нарийвчилсан зохицуулалтыг бий болгоно;

- Төрийн бус байгууллага, тэр дундаа мэргэжлийн холбоодын бүртгэлийн асуудлыг боловсронгуй болгож, тэдгээрийн эвлэрлийн гэрээний биелэлтийг хангах механизмыг тодорхойлно;

- Сингапурын эвлэрүүлэн зуучлалын конвенц,²² ЮНИСТРАЛ-ын Загвар хуульд²³ заасан нөхцөлүүдэд нийцүүлэн арилжааны хил дамнасан эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зохицуулна;

- Хуулийн үйлчлэх хүрээг олон улсын жишиг хандлагад нийцүүлэн өргөжүүлнэ. Тухайлбал, арилжаа, хөрөнгө оруулалтын харилцаанаас үүссэн бусад маргааныг эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлэх зохицуулалтыг тусгана;

- Эвлэрлийн үйл ажиллагааг уян хатан болгож бие даасан, тэгш байдлын зарчмын үзэл баримтлалыг тусгах буюу эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтайгаар маргаанаа шийдвэрлэх эсэхийг сонгох боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгана;

- Эвлэрлийн гэрээний талаар тусгана. Тухайлбал, Эвлэрлийн гэрээ нь маргааныг эвлэрлийн аргаар шийдвэрлэхээр хуульд заасан журмын дагуу хийсэн хэлэлцээг ойлгох байдлаар томъёолно;

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаатай уялдуулан Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны 30 хоногийн хугацааг богиносгоно;

- Эвлэрүүлэн зуучлуулах талууд төлбөр хураамжийг тэгш байдлын зарчмын дагуу төлөх нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн шүүхийн бус эвлэрүүлэн зуучлагчийн төлбөрийн зохицуулалтыг тодорхой болгоно;

- Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах хэлбэрийг нэмэгдүүлж, цахим хэрэгслээр дамжуулан оролцох, баталгаажуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

²¹ мөн тэнд.

²² https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/singapore_convention_eng.pdf

²³ https://uncitral.un.org/sites/uncitral.un.org/files/media-documents/uncitral/en/annex_ii.pdf

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дараах эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар үүснэ. Үүнд:

-Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар шүүхийн ачаалал буурах, арилжаа, хөрөнгө оруулалтын харилцаа нэмэгдэх зэрэг эерэг үр дагавар үүснэ.

-Иргэний эрх зүйн харилцааны оролцогчдын эрх, ашиг сонирхол хангагдах, маргаан шийдвэрлэх субъектээ өөрөө сонгож, хурдан шуурхай, ажил хэргийн нэр хүндэд нөлөөлөхгүй нууцлал сайтай, хараат бус, хөндлөнгийн бие даасан механизмаар маргаанаа шийдвэрлүүлэх нөхцөл бэхжинэ.

-Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулах хэлбэрийг нэмэгдүүлж, цахим хэрэгслээр дамжуулан оролцох, баталгаажуулах эрх зүйн орчныг бүрдүүлснээр эвлэрүүлэн зуучлалаар маргаанаа шийдвэрлүүлэх оролцогчдын тоо нэмэгдэж, ажиллагаа хүртээмжтэй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулах бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг хүчингүй болгох тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

---oOo---